



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2026/001/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баруун-Урт 2026 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1 Албан шаардлага	8
5.2 Зөвлөмж	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.03.15 № 193

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд ахмадын сувилалд зарцуулсан хүнс, материалын зардлын бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шууд зардалд тусгасан байдал нь уг зардлын бүрэн байдал, үнэн зөв байдалд материаллаг буруу илэрхийлэл үүсэх эрсдэлтэй тул аудитын явцад онцгой анхаарал хандуулсан. Аудитын хүрээнд холбогдох баримт, зарцуулалтын үндэслэл, бүртгэлийн нийцлийг шалгаж, нэмэлт сорил гүйцэтгэн дүгнэлт хийсэн

Бусад асуудал

Сүхбаатар аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулж, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	203,043,077.30	133,614,672.20
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	107,284,939.30	26,220,870.20
31100	1.1.1.01 Кассанд байгаа бэлэн мөнгө	6,985.00	6,985.00
31110	1.1.1.01.01 Төгрөг	6,985.00	6,985.00
31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	107,277,954.30	26,213,885.20
31210	1.1.1.02.01 Төгрөг	107,277,954.30	26,213,885.20
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	107,277,954.30	26,213,885.20
33	1.1.3 АВЛАГА	32,746,836.00	26,987,970.00
33500	1.1.3.07 Бусад авлага	32,746,836.00	26,987,970.00
33520	1.1.3.07.02 Хувь хүмүүсээс авах авлага	32,746,836.00	26,987,970.00
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	63,011,302.00	80,405,832.00
35400	1.1.5.04 Хангамжийн материал	63,011,302.00	80,405,832.00
35420	1.1.5.04.02 Аж ахуйн материал	63,011,302.00	80,405,832.00
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	472,514,657.31	423,316,351.35
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	472,514,657.31	423,316,351.35
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	382,514,657.31	332,784,684.68
39201	1.2.2.02.01 Барилга, байгууламж, орон сууц	218,619,466.56	218,619,466.56
39202	1.2.2.02.02 Хуримтлагдсан элэгдэл	(37,748,722.90)	(45,001,000.23)
39203	1.2.2.02.03 Авто-тээврийн хэрэгсэл	180,679,866.73	66,303,866.77
39204	1.2.2.02.04 Хуримтлагдсан элэгдэл	(45,878,626.69)	(29,695,400.06)
39205	1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер)	72,543,879.00	86,149,260.00
39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	(35,629,778.00)	(21,874,752.94)
39207	1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил	212,768,551.00	204,455,225.00
39208	1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл	(182,839,978.39)	(146,171,980.42)
39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	90,000,000.00	90,531,666.67
39301	1.2.2.03.01 Програм хангамж	-	550,000.00
39302	1.2.2.03.02 Хуримтлагдсан элэгдэл	-	(18,333.33)
39303	1.2.2.03.03 Бусад биет бус хөрөнгө	90,000,000.00	90,000,000.00
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	675,557,734.61	556,931,023.55
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	381,812,625.33	299,480,783.50
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	381,812,625.33	299,480,783.50
41300	2.1.1.03 Өглөг	16,922,901.65	7,711,223.81
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	16,922,901.65	7,711,223.81
41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	2,874,599.00	-
41363	2.1.1.03.06.03 Татварын өглөг /ТӨҮГ/	14,048,302.65	7,711,223.81
41400	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	364,889,723.68	291,769,559.69
41440	2.1.1.04.04 Бусад урьдчилж орсон орлого	364,889,723.68	291,769,559.69
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	293,745,109.28	257,450,240.05
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	293,745,109.28	257,450,240.05
51100	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	419,690,240.18	419,690,240.18
511002	2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	419,690,240.18	419,690,240.18
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	(125,945,130.90)	(162,240,000.13)
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	(240,404,379.84)	(125,945,130.90)

51220	2.2.1.08.02	Тайлант үеийн үр дүн	114,459,248.94	(36,294,869.23)
6	2	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	675,557,734.61	556,931,023.55

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	983,343,589.82	950,974,820.31
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	983,343,589.82	950,974,820.31
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	983,343,589.82	950,974,820.31
120010	1.1.1.04.1.10 Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	983,343,589.82	950,974,820.31
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	868,884,340.88	987,269,689.54
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	868,884,340.88	987,269,689.54
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	868,884,340.88	987,269,689.54
2102	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	84,261,048.22
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	868,884,340.88	903,008,641.32
210811	1.1.2.01.1.08.11 Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	691,690,053.07	719,257,283.94
210812	1.1.2.01.1.08.12 Санхүүгийн зардал /ТӨҮГ/	131,400.00	249,104.00
210813	1.1.2.01.1.08.13 Бусад зардал /ТӨҮГ/	164,345,192.81	183,502,253.38
210814	1.1.2.01.1.08.14 Орлогын татварын зардал /ТӨҮГ/	12,717,695.00	-
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	114,459,248.94	(36,294,869.23)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	114,459,248.94	(36,294,869.23)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		-		
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-		
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл		-		
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн		-		
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	419,690,240.18	-	(125,945,130.90)	293,745,109.28
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		-		
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл		-		
19	1.7 Тайлант үеийн үр дүн		-	(36,294,869.23)	(36,294,869.23)
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	419,690,240.18	-	(162,240,000.13)	257,450,240.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	992,182,394.00	966,524,722.95
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	992,182,394.00	966,524,722.95
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	992,182,394.00	966,524,722.95
120009	1.1.1.1.04.1.09 Бусад орлого	20,860,486.00	97,715,706.95
120013	1.1.1.1.04.1.10 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	149,181,940.00	188,286,403.00
120017	1.1.1.1.04.1.14 Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/	822,139,968.00	680,522,613.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	880,741,735.95	994,991,312.05
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	880,741,735.95	994,991,312.05
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	880,741,735.95	994,991,312.05

2101	1.1.1.2.01.1.01	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	484,006,362.00	640,634,554.78
210106	1.1.1.2.01.1.01.06	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	484,006,362.00	640,634,554.78
2102	1.1.1.2.01.1.02	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,417,325.06	84,261,048.22
2103	1.1.1.2.01.1.03	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,999,868.50	5,331,912.19
210305	1.1.1.2.01.1.03.05	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	7,999,868.50	5,331,912.19
2104	1.1.1.2.01.1.04	Хангамж, бараа материалын зардал	124,968,584.35	184,829,784.00
210409	1.1.1.2.01.1.04.07	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	9,835,413.00	7,032,649.00
210410	1.1.1.2.01.1.04.08	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	115,133,171.35	177,797,135.00
2108	1.1.1.2.01.1.08	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,349,596.04	79,934,012.86
210816	1.1.1.2.01.1.08.11	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	50,481,736.04	71,434,213.86
210817	1.1.1.2.01.1.08.12	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	22,000.00
210818	1.1.1.2.01.1.08.13	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	74,867,860.00	8,477,799.00
III	1.1.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	111,440,658.05	(28,466,589.10)
IV	1.1.2.1	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,000,000.00	-
140001	1.1.2.1.01	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,000,000.00	-
V	1.1.2.2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	50,877,800.00	52,597,480.00
22	1.1.2.2.01	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,877,800.00	52,597,480.00
2200	1.1.2.2.01.1	Дотоод эх үүсвэрээр	50,877,800.00	52,597,480.00
225101	1.1.2.2.01.1.07	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	50,877,800.00	52,047,480.00
225102	1.1.2.2.01.1.08	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	-	550,000.00
VI	1.1.2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(46,877,800.00)	(52,597,480.00)
VIII	1.1	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	64,562,858.05	(81,064,069.10)
101	1.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	42,722,081.25	107,284,939.30
20	1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	107,284,939.30	26,220,870.20

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Эдийн засгийн үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны Гүйцэтгэл	2025 оны Төлөвлөгөө	2025 оны Гүйцэтгэл
2	3	2	5	7
Оны эхний үлдэгдэл				
Нийт орлого	төг	713,231.00	1,143,177.00	950,974.00
Үүнээс: Цэвэр борлуулалт	төг	713,231.00	279,278.00	950,974.00
Улсын болон орон нутгийн төсвийн татаас	төг	-	863,899.00	751,982.00
түрээс				
Бусад гэх мэт				
Нийт зардал	төг	766,093.00	1,110,601.00	988,011.00
Үүнээс: Удирдлагын зардал	төг	766,093.00	1,110,601.00	988,011.00
Татварын өмнөх ашиг /алдагдал/	төг	(52,862.00)	32,576.00	(37,037.00)
Цэвэр ашиг /алдагдал/	төг	(47,575.80)	29,318.40	37,037.00
Нийт ажиллагсдын тоо	хүн	35.00	35.00	35
Нийт цалингийн сан	төг	627,715.00	868,821.00	680522
Нэг ажилтаны дундаж цалин	төг	17,934.71	24,823.46	19443
Борлуулалтын / 1төгрөгт ноогдох зардал өссөн дүнгээр/	төг	1	1	1

Хөрөнгө оруулалт, их засвар ТЭБАХ	төг	50,000.00	100,000.00	30,000.00
Нийт авлага	төг	-	32,746.00	26,987.00
Үүнээс: найдвартай	төг	-	32,746.00	26,987.00
найдваргүй	төг	0	0	0
Нийт өглөг	төг	0	4,505.00	7,711.00
Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	төг	0	4,505.00	7,711.00
Урт хугацаат өр төлбөр	төг			
Нийт хөрөнгийн дүн	төг	0		555,688.60
эргэлтийн хөрөнгө	төг	0		133,614.00
үүнээс бараа материал	төг	0		80,405.00
үндсэн хөрөнгө	төг	0		422,073.90

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 111,948.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрснээс 20,416.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 91,531.4 мянган төгрөгийн алдаанд 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

“Амгалан дэнж” ахмадын сувилалд зарцуулсан хүнс, материалын зардлыг худалдан авсан өдрөөр нь шууд шаардах хуудсаар зарлага болгож, бүртгэсэн бөгөөд ямар төрлийн хоол хүнс бэлтгэж олгосон, хэдий хэмжээний материал ашигласан талаар нотлох анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2024 оны А/03 тоот тушаалтай нийцэхгүйд албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

5.2 Бараа материалын бүртгэлтэй холбоотой

5.2 Илрүүлэлт.

Хоол хүнс бэлтгэхэд ашиглах зорилгоор худалдан авсан нийт 91,531.4 мянган төгрөгийн үнэ бүхий хүнс, хүнсний материалыг зориулалтын ангиллаар бүртгэлгүй, нягтлан бодох бүртгэлд бусад хангамжийн бараа материал гэсэн ангилалд бүртгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2024 оны А/03 тоот тушаалтай нийцэхгүй байна .

Өгсөн зөвлөмж:

Хоол хүнс бэлтгэхэд зориулан худалдан авсан хүнс, хүнсний материалыг зориулалтын ангиллын дагуу нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж, бараа материалын ангиллыг бодит зориулалт, шинж чанарт нь нийцүүлэн ялган бүртгэх, анхан шатны баримтаар баталгаажуулан орлого, зарлагын хөдөлгөөнийг бүрэн тусгаж, тайлагналын үнэн зөв, иж бүрэн байдлыг ханган, холбогдох бүртгэлийн бодлого, дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
“Амгалан дэнж” ахмадын сувилалд зарцуулсан хүнс, материалын зардлыг худалдан авсан өдрөөр нь шууд шаардах хуудсаар зарлага болгож, бүртгэсэн бөгөөд ямар төрлийн хоол хүнс бэлтгэж олгосон, хэдий хэмжээний материал ашигласан талаар нотлох анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлээгүй байгаа	1	20,416.6	-	-	1	20,416.6			-	-	-	-
Хоол хүнс бэлтгэхэд ашиглах зорилгоор худалдан авсан нийт 91,531.4 мянган төгрөгийн үнэ бүхий хүнс, хүнсний материалыг зориулалтын ангиллаар бүртгэхийн оронд нягтлан бодох бүртгэлд бусад хангамжийн бараа материал гэсэн ангилалд бүртгэсэн байна.	1	91,531.4					1	91,531.4				
Дүн	2	111,948.1	-	-	1	20146.6	1	91,531.4	-	-	-	-